

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн
нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2024 он

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317

Цахим хаяг: Erdnebaatara@audit.gov.mn

Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114

Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Давааням Утас: 92113932

Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Ичинхорлоо Утас: 88012671

Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор Л.Мандахнаран Утас: 92118277

Цахим хаяг: Mandakhnaranl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/ мянган төгрөгөөр/	
			2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		41,715,793.20	47,840,653.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	19,951,988.60	20,291,859.40
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	8,377,838.40	8,412,034.80
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	382,597.40	719,017.00
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	10,858,319.90	16,217,007.80
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	424,835.40	209,259.70
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	1,992,575.00	1,991,475.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		146,632,983.40	163,695,277.60
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	2,432,742.30	2,883,862.90
37300	Урт хугацаат зээл		2,432,742.30	2,883,862.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	144,200,241.20	160,811,414.70
39200	Биет хөрөнгө		130,146,078.60	135,563,755.40
39300	Биет бус хөрөнгө	13	13,247,726.80	24,443,705.20
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	806,435.80	803,954.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		188,348,776.70	211,535,931.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		23,341,150.10	29,290,029.40
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	10,026,538.10	16,229,732.20
41300	Өглөг	17а, 17б	8,409,032.70	12,953,697.80
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,617,505.50	3,276,034.40
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		13,314,612.00	13,060,297.20
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	13,314,612.00	13,060,297.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		165,007,626.60	182,245,901.80
51	Засгийн газрын хувь оролцоо		164,966,975.10	182,205,250.40
51100	Засгийн газрын оруулсан капитал		37,162,596.90	49,172,227.10
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/		41,967,927.00	42,312,105.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		15,173,445.70	15,851,915.70
51200	Хуримтлагдсан үр дүн		44,335,360.10	48,939,447.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		26,327,645.40	25,966,337.80
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		0	-36,783.30
52	Хяналтын бус хувь оролцоо		40,651.50	40,651.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		188,348,776.70	211,535,931.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/ мянган төгрөгөөр/	
			2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		82,103,262.5	92,574,889.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО		24,095,555.2	26,906,206.0
110	Орлогын албан татвар		13,868,524.6	17,889,307.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		14,488,418.1	18,721,523.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-910,750.4	-1,187,545.2
1103	ААН-ын орлогын албан татвар		290,857.0	355,329.2
113	Хөрөнгийн албан татвар		2,929,943.1	3,487,349.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж		7,297,087.5	5,529,549.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	41,037,355.2	56,051,385.1
120	Нийтлэг татварын бус орлого		9,217,820.8	14,905,802.6
121	Хөрөнгийн орлого		1,258,200.3	169,171.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		30,561,334.1	40,976,411.1

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		16,970,352.0	9,617,298.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	78,618,586.6	85,566,622.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ		77,503,044.5	84,584,790.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		67,989,542.4	66,175,799.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		13,340,225.0	16,923,089.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,661,006.5	2,137,276.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		8,002,930.6	932,585.3
2104	Хангамж, бараа материалын зардал		15,395,847.6	8,048,268.1
2105	Нормативт зардал		240,715.5	291,220.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		1,663,179.2	664,551.6
2107	Томилолт, зочны зардал		186,362.5	363,492.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,861,576.9	19,689,782.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		16,637,698.6	17,125,532.7
212	ТАТААС		1,062,694.9	2,214,418.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,450,807.2	16,194,573.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		1,115,542.1	981,831.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		3,484,675.8	7,008,267.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		4,015.4	92,167.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		180,489,353.9	1,881,672.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-177,000,662.6	5,218,763.0

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	336,737,753.1	336,737,753.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,625,775.3	-1,625,775.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,111,977.8	335,111,977.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	179,281.7	179,281.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	988,452.0	988,452.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	5,733,577.6	5,733,577.6
8	Зарласан ногдол ашиг	-5,000.0	-5,000.0
9	Тайлант үеийн үр дүн	-177,000,662.6	-177,000,662.6
10	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	165,007,626.6	165,007,626.6
11	2023 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл	165,007,626.6	165,007,626.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-401,544.1	-401,544.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,606,082.5	164,606,082.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-246,215.3	-246,215.3
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	11,430,207.1	11,430,207.1
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,369,136.0	1,369,136.0
18	Зарласан ногдол ашиг	-5,000.0	-5,000.0
19	Тайлант үеийн үр дүн	5,091,691.5	5,091,691.5
20	2023 оны 12-р сарын 31-аар үлдэгдэл	182,245,901.8	182,245,901.8

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	106,561,434.3	120,828,539.8

11	ТАТВАРЫН ОРЛОГО	24,740,698.2	26,865,985.2
110	Орлогын албан татвар	14,513,667.6	17,849,086.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	14,488,418.1	18,681,302.7
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-910,750.4	-1,187,545.2
1103	ААН-ын орлогын албан татвар	936,000.0	355,329.2
113	Хөрөнгийн албан татвар	2,929,943.1	3,487,349.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	7,297,087.5	5,529,549.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,034,744.7	1,889,753.8
1181	Газрын төлбөр	763,601.8	969,925.0
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	5,495,257.4	2,669,870.5
1183	Бусад татвар	3,483.6	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	64,305,904.6	84,022,578.0
120	Нийтлэг татварын бус орлого	32,486,370.2	42,876,995.5
121	Хөрөнгийн орлого	1,258,200.3	169,171.4
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	30,561,334.1	40,976,411.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,514,831.4	9,939,976.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,188,859.8	104,284,879.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,188,859.8	104,284,879.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,809,621.2	84,729,175.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	19,488,014.4	24,686,607.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,671,286.4	4,567,487.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,090,636.4	2,681,181.5
2104	Хангамж, бараа материалын зардал	18,149,846.1	20,650,421.8
2105	Нормативт зардал	235,357.2	301,732.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,475,269.7	589,743.9
2107	Томилолт, зочны зардал	157,815.8	340,568.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,308,671.5	24,357,397.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,232,723.8	6,554,034.1
212	ТАТААС	1,062,694.9	2,214,418.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,316,543.7	17,341,285.8
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	22,372,574.5	16,543,660.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	19,542,879.2	13,023,850.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,542,879.2	13,023,850.8
2200	Дотоод эх үүсвэрээр	19,542,879.2	13,023,850.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-19,542,879.2	-13,023,850.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2,996,773.5	-3,179,938.5
14	Бусад эх үүсвэр	0.0	21,157.7
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,504,460.2	2,110,554.7
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	492,313.2	1,090,541.5
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-167,078.2	339,870.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	20,119,066.8	19,951,988.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	19,951,988.6	20,291,859.4

5.2 Төлбөрийн акт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогүй болно.

5.3 Албан шаардлага

1. Санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсантай холбоотой асуудал

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” санал дүгнэлт авсан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. *“Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”* гэх заалтыг үндэслэн сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2. Орон нутгийн өмчит компаниудын үйл ажиллагаатай холбоотой

- Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмчтэй “Урандөш хүүхдийн зуслан” ОНӨААТҮГ, “Эрчимт илч түлш” ХХК, “Шишхэдийн харгуй” ХХК гэсэн компаниуд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байна. Тус компаниуд нь тогтсон үйл ажиллагаа явуулдаггүй, тодорхой нягтлан бодогчгүй, үйл ажиллагаа жигдрээгүй, компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт алдагдсан байна. “Эрчимт илч түлш” ХХК нь 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй байж 21.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тус компаниуд нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй боловч компанийн ашигт ажиллагааг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх талаар бодитой авсан арга хэмжээ байхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 дахь заалт *“Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах; гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.* Тус зөрчилд Орон нутгийн өмчит Компаниудын ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагааг сайжруулах талаар судалж бодитой арга хэмжээ авч ажиллах **албан шаардлагыг** тус компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3. Мал хамгаалах сангийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал:

- Мал хамгаалах сангийн санхүүгийн тайланд сумдад олгосон өвс, тэжээлийн тооцооны 58.9 сая төгрөгийн авлагын үлдэгдэл бүртгэлтэй байгаа боловч дэлгэрэнгүй бүртгэл байхгүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* заалттай нийцэхгүй ба “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Мал хамгаалах санд бүртгэлтэй 17.4 сая төгрөгийн өвс тэжээлийн нөөцийн үлдэгдлийг тооллого хийж баталгаажуулаагүй, 32.1 сая төгрөгийн өвс тэжээлийг акталсан гэх боловч холбогдох анхан шатны баримт байхгүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2. *“Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ. 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэсэн заалтуудыг зөрчсөн, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Дээрх зөрчлүүдэд өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Сумдын төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Алаг-Эрдэнэ, Их-Уул, Ханх, Цагаан-Үүр, Эрдэнэбулган сумдын санхүү албаны дарга нь төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа нь тухайн сумын төлбөр тооцоонд тавих дотоод хяналт алдагдах эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 *“Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”* гэсэн заалттай нийцээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Сумдын санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнийг тусдаа албан хаагчаар гүйцэтгүүлэх саналыг хүргүүлж, төлбөр тооцоонд тавих хяналт алдагдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх

2. Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Түнэл, Рашаант сумдад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Орон нутгийг дэмжих Шинэ хөдөө төсөл"-ийн хүрээнд ирсэн 107.4 сая төгрөгийн барша помп тоног төхөөрөмжийг бодитоор хүлээн аваагүй байхад Орон нутгийн өмчийн газрын даргын 2022 оны А/90 дүгээр тушаалаар бүртгэл тайлагналд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *“үнэн зөв байх”*, 14 дүгээр зүйлийн 14.4.2. *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”*; гэсэн заалттай нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хөрөнгийг хүлээн авахтай холбоотой асуудлыг холбогдох газарт хандаж шийдвэрлэх

3. Компанийн удирдлага, санхүүтэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмчтэй “Урандөш хүүхдийн зуслан” ОНӨААТҮГ, “Эрчимт илч түлш” ХХК, “Шишхэдийн харгуй” ХХК гэсэн компаниуд Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байна. Тус компаниуд нь тогтсон үйл ажиллагаа явуулдаггүй, тодорхой нягтлан бодогчгүй, үйл ажиллагаа жигдрээгүй, компанийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт алдагдсан байна. “Эрчимт илч түлш” ХХК нь 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй байж 21.5 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тус компаниуд нь Төлөөлөн удирдах зөвлөлтэй боловч компанийн ашигт ажиллагааг сайжруулах, хяналтыг хэрэгжүүлэх талаар бодитой авсан арга хэмжээ байхгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2 *“Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах”* гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн өмчит Компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

4. Авлагатай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулгад авлагын мэдээллийг оруулахдаа авлагын насжилт болон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг 436.4 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна. Авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнасан эсэхэд хяналт тавьж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 *“аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн, "толилуулга" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2 Өгсөн зөвлөмж:

Авлагын насжилт болон хугацаа хэтрэлтийг тодруулга тайланд үнэн зөв ангилан бүртгэхэд хяналт хэрэгжүүлж ажиллах

Аймгийн Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн хүрээнд харьяа байгууллагуудын арилжааны банканд байршиж буй данснууд, барьцаа хөрөнгө, техник хяналтын данс, авлага болон урьдчилж гарсан зардал, авлагын насжилт, барилга байгууламж, дуусаагүй барилга, программ хангамж, өр төлбөр урьдчилж орсон орлого, зээл үнэт цаас, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, ашиг алдагдал болон ногдол ашгийн судалгааг нэгтгэж, үр дүнг тайланд тусгасан болно.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ТЕЗ	13	8,184,415.1	7	587,785.5	6	7,596,629.6	13	6,690,503.2		
Харьяа байгууллагуудын зөрчил										
ТТЗ	6	2,429,442.5			6	2,429,442.5	6	2,429,442.5		
ТШЗ	21	1,485,433.3			21	1,485,433.3	21	1,485,433.3		
ОНӨХХК	31	3,720,277.9			31	3,720,277.9	31	3,720,277.9		
Дүн	71	15,819,568.8	7	587,785.5	64	15,231,783.3	71	14,325,656.9	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТЕЗ	8	648,178.5			4	108,367.6	3	539,810.9	1	1		
Харьяа байгууллагуудын зөрчил												
ТТЗ	24	1,002,900.4					24	1,002,900.4				
ТШЗ	81	2,794,450.3	14	34,566.9	9	56,398.5	52	2,576,510.1	4	4	1	11,415.6
ОНӨХХК	103	7,466,361.6	13	34,988.5	12	1,495,271.2	52	5,938,101.9	1	1		
Дүн	216	11,911,890.8	27	69,555.4	25	1,660,037.3	131	10,057,323.3	6	6	1	11,415.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								

ТШЗ	12	726,987.4			1	448,457.1	11	278,530.4
ОНӨ ХХК	10	850,722.2			3	345,882.3	7	504,893.8
Дүн	22	1,577,709.6	0	0	4	794,339.4	18	783,424.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТЭЗ	1	0					1	0
Дүн	1	0					1	0
Нийт дүн	23	1,577,709.6	0	0	4	794,339.4	19	783,424.2